



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 08 сарын 28 өдөр

Дугаар 58

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. "Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нарт урамшуулал олгох, иргэд сонгогчидтой ажиллахад нь дэмжлэг үзүүлэх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хурлын ажлын албаны дарга /Ц.Алтанцацрал/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТӨЛӨӨЛӨГЧ НАРТ УРАМШУУЛАЛ ОЛГОХ, ИРГЭД СОНГОГЧИДТОЙ
АЖИЛЛАХАД НЬ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 08 дугаар тогтоолын дагуу Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн /цаашид Хурлын Төлөөлөгч гэх/ бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Хурлын ажилд оролцох оролцоог үнэлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд урамшуулал олгох, иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь дэмжлэг үзүүлэх журмын зорилго нь /цаашид журам гэх/ Хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгох, дүүргийн эдийн засаг нийгмийн олон талт асуудлуудыг цаг тухай бүрд нь шийдвэрлэх болон Төлөөлөгч нар иргэд сонгогчидтойгоо байнгын харилцаа холбоо тогтоож ажиллахад дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд оршино.

Хоёр. Хурлын Төлөөлөгчийн оролцоо, бүртгэл

2.1. Хурлын Төлөөлөгч хурлаас зохион байгуулсан ажил, арга хэмжээнд оролцсон талаарх тайлан, мэдээгээ улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор бичгээр гаргаж Хурлын ажлын албанд ирүүлнэ.

2.2. Хурлын Төлөөлөгч нам, эвслийн бүлгийн хуралд оролцсон тухай ирцийн мэдээ, Төлөөлөгчдийн иргэд, сонгогчидоо хандаж хийсэн ажлууд, шинэлэг бүтээлч ажлын жагсаалт, өргөдөл гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэсэн байдлын талаарх тайлан мэдээг намын бүлгийн ажилтнууд нэгтгэн бүлгийн дарга баталгаажуулан улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор Хурлын ажлын албанд ирүүлнэ.

2.3. Хурлын Төлөөлөгч Хурлын нэгдсэн хуралдаан болон хорооны хуралд оролцсон ирц, Хурлаас зохион байгуулсан ажлын хэсгийн хурал, зохион байгуулсан ажилд оролцсон байдлын талаарх мэдээ, судалгааг Хурлын ажлын албаны Төлөөлөгч хариуцсан ажилтан бүртгэл хөтөлж улирал бүрийн сүүлийн сарын 22-ны дотор нэгтгэнэ.

2.4. Шаардлагатай нөхцөлд Хурлын Төлөөлөгч ажлын тайлангаа Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж болно.

2.5. Хурлын ажлын алба, намын бүлгүүдээс ирсэн тайлан мэдээг Хурлын Төлөөлөгч хариуцсан ажилтан нэгтгэнэ. Ажлын албаны дарга нэгдсэн тайлан

дэмжлэгийн хэмжээ 2.500.000 төгрөг байна. Санхүүгийн дэмжлэгийг улирал бүрийн эхний сард олгоно.

4.3. Хурлын Төлөөлөгчид иргэд сонгогчидтойгоо дараах чиглэлийн дагуу ажиллахад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Үүнд:

- Иргэд, сонгогчдынхоо дунд зохион байгуулах төрөл бүрийн арга хэмжээ, тохижилт соёлжилтын ажилд дэмжлэг үзүүлэх;
- Нэн ядуу амьдралтай иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх;
- Иргэд, сонгогчдын дунд тэмцээн уралдаан, хэлэлцүүлэг, уулзалт ярилцлага зохион байгуулах;
- Амьдралын хүнд нөхцөлд амьдарч байгаа оюутанд тусламж дэмжлэг үзүүлэх;
- Идэвхи санаачлагатай ажиллаж байгаа иргэд, сонгогчдыг шагнаж урамшуулах;
- Хүнд нөхцөлд байгаа иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчинг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гарсан иргэдийн санал санаачлагыг дэмжих, иргэдийн оролцоог урамшуулах;
- Иргэдийн амьжиргааг дэмжих, ажлын байртай болгох ажлыг зохион байгуулах;
- Хорооныхоо иргэдийн ая тухтай амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх бүхий л төрлийн арга хэмжээг зохион байгуулах;
- Бусад

Тав. Хурлын Төлөөлөгч нарт урамшуулал олгох, иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэлийг тооцох

5.1. Хурлын Төлөөлөгч нарт олгох мөнгөн урамшуулал, иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь дэмжлэг үзүүлэх мөнгийг Хурлын төсвөөс олгоно.

5.2. Хурлын Төлөөлөгч нарт олгох урамшууллын хэмжээг Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

5.3. Хурлын Төлөөлөгч иргэд сонгогчидтойгоо ажиллах ажлын төлөвлөгөөгөө улирал бүрийн эхний сарын 05-ны дотор Хурлын ажлын албаны Төлөөлөгч хариуцсан ажилтанд гаргаж өгнө.

5.4. Хурлын Төлөөлөгч зохион байгуулсан ажлын тайланг холбогдох санхүүгийн баримт бичгийн хамт Хурлын ажлын албаны нягтлан бодогчид дараа улирлын эхний сарын 10-ны дотор гаргаж өгнө.

5.5. Тайлан болон санхүүгийн баримт бичгээ цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй Төлөөлөгчид дараагийн улирлын урамшуулал болон санхүүгийн дэмжлэгийг олгохгүй.

5.6. Хурлын Төлөөлөгчид олгох урамшуулал, иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх мөнгийг Хурлын Төлөөлөгч нарын банкны карт руу шилжүүлнэ.

мэдээг Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулан тогтоол гарган шийдвэрлүүлнэ.

Гурав. Хурлын Төлөөлөгч нарт урамшуулал олгоход баримтлах зарчим, шалгуур, үнэлгээ

3.1. Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хурлын Төлөөлөгч нарт Хурлын үйл ажиллагаанд оролцсон байдал, ажлын үр дүн, идэвхи санаачлагыг харгалзан 5.000.000 төгрөг хүртэл мөнгөн урамшуулал, иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

3.2. Хурлын Төлөөлөгч нарт олгох мөнгөн урамшууллыг улиралд нэг удаа олгох бөгөөд нэг Төлөөлөгчид олгох урамшуулалын хэмжээ 2.500.000 төгрөг хүртэл байна. Мөнгөн урамшууллыг улирал бүрийн сүүлийн сард олгоно.

3.3. Хурлын Төлөөлөгч нарт олгох мөнгөн урамшуулалын хувь хэмжээг Төлөөлөгч нэг бүрээр тодорхойлж, улирал бүрийн эцсээр тооцон гаргана. Урамшуулалын хувь хэмжээг тооцохдоо дараах үзүүлэлтийг хагалзан үзнэ.

- 3.3.1. Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдаанд оролцсон байдал;
- 3.3.2. Хурлын хороо болон ажлын хэсгийн хуралдаанд оролцсон байдал;
- 3.3.3. Хурлаас байгуулсан ажлын хэсэг, түр хороонд ажилласан байдал;
- 3.3.4. Сонгогдсон хороондоо болон сонгогчидтой ажилласан байдал;
- 3.3.5. Хурлаас зохион байгуулсан ажилд оролцсон байдал;

3.4. Дээрх шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэж үзүүлэлт бүрийг үнэлэх оноо өгч дүнг нэгтгэн дараах байдлаар тооцож гаргана.

ДД	Үзүүлэлт	Оноо
1	Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдаанд оролцсон байдал	0-5
2	Хурлын хороо болон ажлын хэсгийн хуралдаанд оролцсон байдал	0-5
3	Хурлаас байгуулсан ажлын хэсэг, түр хороонд ажилласан байдал	0-5
4	Сонгогдсон хороондоо болон сонгогчидтой ажилласан байдал	0-5
5	Хурлаас зохион байгуулсан ажилд оролцсон байдал	0-5
Авбал зохих оноо		25

- 0-5 оноо авсан бол 500,000 хүртэл төгрөг олгоно
- 6-10 оноо авсан бол 1,000,000 хүртэл төгрөг олгоно
- 11-15 оноо авсан бол 1,500,000 хүртэл төгрөг олгоно
- 16-20 оноо авсан бол 2,000,000 хүртэл төгрөг олгоно
- 21-25 оноо авсан бол 2,500,000 хүртэл төгрөг олгоно

3.5. Төлөөлөгчдийн тусгайлсан мэдээллийн санг үүсгэнэ.

Дөрөв. Хурлын Төлөөлөгчийн иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хийгдэх ажлын чиглэл

4.1. Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хурлын Төлөөлөгчид иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

4.2. Хурлын Төлөөлөгч иргэд сонгогчидтойгоо ажиллахад нь үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг улиралд нэг удаа олгох бөгөөд нэг Төлөөлөгчид олгох



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Хурлын Төлөөлөгчдөд урамшуулал
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд оролцсон байдал, ажлын үр дүн, идэвх санаачилгыг харгалзан улирал бүр 5000000 /таван сая/ хуртгал төгрөгийн мөнгөн урамшуулал олгож байхаар шийдвэрлэсүгэй.

2. Хурлын Төлөөлөгчдийн хийсэн ажлын тайлан, мэдээг нэгтгэн дүгнэж Төлөөлөгчдөд олгох урамшууллын мөнгөн дүнг жагсаалтаар гарган улирал бүрийн эхний сарын 05-ны дотор Хурлын Ажлын албанд ирүүлж байхыг Хурал дахь Намуудын бүлгийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөөлөгчдийн хийсэн ажлын тайлан, урамшууллын мөнгөн дүнгийн жагсаалтыг Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж, Хурлын даргын захирамж гаргуулан хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хурлын Ажлын албаны дарга /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



ДБАТ-ЭРДЭНЭ